



НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВ
ЗАХИРАЛ /Б.ГЭРЭЛГУА/

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН СТРАТЕГИ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ БА ЗОРИЛГО

1.1 **Үндэслэл:** Баянгол дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн багш, ажилтнууд нь нийгмийн бүхий л бүлгийн суралцагчидтай ажилладаг тул тэднээс хөрвөх чадвар, дижитал болон заах арга зүйн өндөр ур чадварыг шаарддаг. Энэхүү стратеги нь багш, ажилчдын мэргэжлийн чадамжийг дээшлүүлэх, ажлын байрны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх замаар байгууллагын соёл, сургалтын чанарыг сайжруулахад чиглэнэ. Энэхүү хүний нөөцийн стратегийг 2026-2030 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

1.2 **Бодлогын уялдаа:** Энэхүү стратеги нь Боловсролын багц хууль, Насан туршийн суралцахуйн Амьдрах ухааны сургалтын жишиг хөтөлбөр (Тушаал А/577), МХХТ-ийн чадамжийн хүрээ (Тушаал А/57) болон ЮНЕСКО-гийн Глобал сүлжээний удирдамжтай бүрэн уялдсан бөгөөд дүүргийн хэмжээнд "Суралцагч хот — Баянгол загвар"-ыг нутагшуулахад тулгуурлана.

1.3 **Зорилго:** Багш, ажилтнуудын андрагоги (насанд хүрэгчдийн сургалт)-ийн арга зүй, дижитал чадамж, олон нийттэй ажиллах болон хувь хүний болон багшийн мэргэжлийн хөгжлийн ур чадварыг цогцоор нь хөгжүүлж, насан туршийн суралцахуйн чанартай, хүртээмжтэй үйлчилгээг иргэдэд хүргэхэд оршино. Зорилгоо дараах стратеги зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ.

ХОЁР. СТРАТЕГИ ЗОРИЛТУУД

Зорилт 1: Андрагоги арга зүйн болон багшийн тасралтгүй мэргэжлийн хөгжлийг хангах

Зорилт 2: Дижитал шилжилт ба хиймэл оюун ухаан (AI)-ийг сургалтад хэрэглэх цахим чадамжийг хөгжүүлэх

Зорилт 3: Орон нутгийн сурах хэрэгцээг тодорхойлох, датад суурилсан "Судлаач-багш" чадавхыг бэхжүүлэх

Зорилт 4: Ажлын байрны сэтгэл зүйг дэмжих, эерэг соёлыг төлөвшүүлэх

Зорилт 5: "Суралцагч хот Баянгол" загварын хүрээнд олон нийтийн оролцоо, гадаад түншлэлийг өргөжүүлэх

ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

3.1. АНДРАГОГИ БА ОРЧИН ҮЕИЙН ЗААХ АРГА ЗҮЙ

3.1.1. Насанд хүрэгчдийн сургалтын онцлог: Боловсролын Сайдын А/577 тушаалаар баталсан 'Хувь хүний хөгжлийг дэмжих амьдрах ухааны сургалтын жишиг хөтөлбөр'-ийн дагуу насанд хүрэгчдийн сэтгэл зүй, сурах хэрэгцээг тодорхойлох, идэвхтэй сургалтын аргуудыг (Flipped classroom, кэйс шинжилгээ) нэвтрүүлэх.

3.1.2. Сургалтын хөтөлбөр боловсруулалт: Үр дүнд суурилсан сургалтын төлөвлөгөө, орон нутгийн онцлогт тохирсон контент бэлтгэх арга техник.

3.1.3. Үнэлгээний арга зүй: Суралцагчдын ахиц дэвшлийг үнэлэх уян хатан, дэмжсэн үнэлгээний хэрэгслүүд.

3.2 ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ БА AI ТЕХНОЛОГИ

3.2.1 Цахим заах арга зүй: Боловсролын Сайдын А/57 тушаалаар баталсан МХХТ-ийн чадамжийн хүрээнд нийцүүлэн Сургалтын удирдлагын систем (LMS) болон цахим платформуудыг (Google Classroom, интерактив хэрэгслүүд) ашиглах чадвар.

3.2.2 Хиймэл оюун ухаан (AI) ба Дижитал эрх мэдэл: Сургалтын хэрэглэгдэхүүн, төлөвлөгөө бэлтгэхэд AI хэрэгслүүдийг ёс зүйтэй, үр дүнтэй ашиглах, орон нутгийн иргэд болон төрийн албан хаагчдыг цахим аялалд чиглүүлэх чадавхыг нэмэгдүүлэх.

3.2.3 Интерактив контент бүтээх: Цахим хичээл, зааварчилгаа бэлтгэх график болон видео хэрэгслүүдийг эзэмших.

3.3 ОРОН НУТГИЙН СУРАХ ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ, ДАТАД СУУРИЛСАН "СУДЛААЧ-БАГШ" ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

3.3.1 Багш зөвхөн хичээл заах биш, орон нутгийн иргэд, зорилтот бүлгийн бодит хэрэгцээг дата-д үндэслэн тогтоох, судалгааны аргад суралцахад чиглэнэ.

3.3.2 Сургалтын хэрэгцээний судалгаа авахад (Excel/Google Sheets) ашиглах, дата мэдээлэл цуглуулах, үр дүнг боловсруулах анхан шатны мэдлэг олгох буюу цахим орчинд мэдээллийн үнэн зөв байдлыг шүүн тунгаах, мэдээллийн дархлааг иргэдэд төлөвшүүлэх чиглүүлнэ.

3.4 АЖЛЫН БАЙРНЫ СЭТГЭЛ ЗҮЙГ ДЭМЖИХ, ЭЕРЭГ СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ

3.4.1 Багш, ажилтнуудын ажлаас халшрах буюу ажлын байрны стрессээс сэргийлэх, сэтгэл зүйг өргөх, сайн туршлага дэлгэрүүлэх замаар дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэх.

3.4.2 Төрийн үйлчилгээний соёл, сахилга хариуцлага, багаар ажиллах чадвар, багшийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих, үе тэнгийн дээрэлхэлд, эрсдэлээс сэргийлэх нөлөөлөл үзүүлж сургалтын болон цагийн менежментийг үр дүнтэй зохион байгуулах, хувийн бүтээмжийг өсгөх

3.5 "СУРАЛЦАГЧ ХОТ БАЯНГОЛ" ЗАГВАРЫН ХҮРЭЭНД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО, ГАДААД ТҮНШЛЭЛИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ

3.5.1 Зорилтот бүлгүүд, ялангуяа ахмад настан, залуучууд, суралцах боломж хязгаарлагдмал иргэдийг Ахмад настны тухай хууль болон бусад бодлогын удирдамжийн дагуу насан туршийн суралцахуйн үйлчилгээнд хамруулах, нөлөөллийн ажил хийж, дүүргийн хэмжээнд "Суралцагч хот"-ны соёлыг бүрдүүлэх

3.5.2 Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын төсөл (ЮНЕСКО-гийн GNLC), хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй "Ногоон боловсрол"-ын хамтын ажиллагааг хөгжүүлэх

3.5.3 Суралцагчдад карьер чиг баримжаа олгох, суралцах сэдэл үүсгэх зөвлөгөө, чиглүүлэг (mentoring) хийх арга зүйг эзэмшүүлэх

4. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭЛБЭРҮҮД

Хөтөлбөрийг онолын сургалтаас гадна дараах идэвхтэй хэлбэрүүдээр зохион байгуулна:

4.1 “Багш багшаасаа суралцах” хөтөлбөр: Туршлагатай зөвлөх багш нар залуу багш нартаа заах арга зүйн зөвлөгөө (Mentorship) өгөх, харилцан туршлага солилцох.

4.2 Кэйс шинжилгээ: Бодит жишээн дээр тулгуурлан асуудал шийдвэрлэх дадлага ажлууд (Дүүргийн түвшинд “Суралцагч хот — Баянгол загвар”-ыг нутагшуулах кэйс дээр ажиллах).

4.3 Микро-суралцахуй (Micro-learning): Дижитал ур чадварыг богино хэмжээний цахим видео, зааврын дагуу бие даан эзэмших, Google Docs зэрэг үүлэн технологи ашиглан багш нар хамтран хөтөлбөр боловсруулах дадлага хийх

5. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН БА ҮНЭЛГЭЭ

5.1 Багш, менежерийн түвшинд: Сургалтын чанар сайжирч, цахим болон AI хэрэгслийн хэрэглээ нэмэгдэнэ. Ажлын байрны стресс буурч, сэтгэл ханамж өснө.

5.2 Байгууллагын түвшинд: Сургалтын төвийн хамтын ажиллагааны хүрээ тэлж, олон нийтэд үзүүлэх нөлөөлөл, нэр хүнд өсөж, ЮНЕСКО-гийн Глобал сүлжээнд “Суралцагч хот — Баянгол загвар” жишиг болон бэхжинэ.

5.3 Үнэлгээний арга: Хагас болон бүтэн жилээр багш нарын гүйцэтгэлийн үнэлгээ (KPI), суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа, ажлын байрны уур амьсгалын индексийг дата анализын аргаар хэмжих. Багш нарын KPI үнэлгээг ЮНЕСКО-гийн “Суралцагч хотууд”-ын олон улсын индикаторуудын биелэлттэй уялдуулна.

5.4 Энэхүү хөтөлбөрийн төлөвлөлтийг жил бүр хийж үр дүн SWOS болон TOWS шинжилгээнд үндэслэн тооцно.

---o0o---

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВ